

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	“Чухал” авто тээврийн хэрэгслийн даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Авто тээврийн хэрэгслийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Тээврийн хэрэгслийн даатгалын шинэ бүтээгдэхүүн батлуулах		2016-11-03		ЗТ-200-2016	
6	Цахимаар борлуулах эсэх	Тийм					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Бүх төрлийн тээврийн хэрэгсэл					
	Даатгалын үндсэн эрсдэл	Зам тээврийн хөдөлгөөн, Зогсоол, Галын, Байгалийн, Хулгайн					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.2%-0.8%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Даатгуулагч даатгалын хураамжийг гэрээнд заасан хугацаанд, хэрэв даатгагчийн зөвшөөрснөөр нэмэлт хугацаа авсан бол тэрхүү хураамж төлөх нэмэлт хугацаанд төлөөгүй тохиолдолд;
2. Жолооч эм хэтрүүлэн, согтууруулах ундаа, мансууруулах эсвэл сэргээх үйлчилгээтэй бодис хэрэглэсэн, хэт ядарсан байсныг мэргэжлийн байгууллага тогтоосон;
3. Хурд хэтрүүлэх, улаан гэрлээр уулзвар нэвтрэх, урсгал сөрөх үед холбогдсон ослын хохирол;
4. Нийтийн ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, замын хөвөө, төв замын нэгдүгээр эгнээ дээр зогсох үед учирсан хохирол;
5. Даатгуулагч даатгалын тохиолдол болсон тухай Даатгагчид нэн даруй мэдэгдээгүй, даатгалын нөхөн төлбөрийн материалыг 60 хоногийн дотор бүрдүүлж ирүүлээгүй тохиолдолд;
6. Хохирлыг нотлох бололцоогүй, хангалттай нотлох баримт бүрдээгүй дор дурдсан аливаа тохиолдол. Үүнд:
 - 6.1. Даатгуулагч учирсан хохирлыг нотлох баримт, дүгнэлт, нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай гэрээнд заасан баримт бичиг, мэдээ мэдээллийг Даатгагчид бүрэн гүйцэд өгөөгүй тохиолдолд;
 - 6.2. Хохирол нь даатгалын хугацаанд болон гэрээнд заасан эрсдэлийн улмаас учирсныг нотлох бололцоогүй тохиолдолд;
 - 6.3. Даатгуулагч тээврийн хэрэгслээр орон нутагт зорчих үедээ гэнэтийн осолд орсон нь баримт нотолгоогоор хангалттай батлагдахгүй бөгөөд уг ослын шалтгааныг тодорхойлсон замын цагдаагийн газрын тодорхойлолт бодитой бус бол;
 - 6.4. Буруутай этгээдээр учирсан хохирлоо төлүүлсэн тохиолдолд;
7. Дор дурдсан эвдрэл гэмтэл бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцсоноос үүдэн гарсан аливаа хохирол. Үүнд:
 - 7.1. Тээврийн хэрэгслийн тоормосны системийн эд ангиудын хийцийг өөрчилсөн, тоормосны системийн битүүмж алдагдсан үед хөдөлгөөнд оролцсоныг мэргэжлийн байгууллага олж тогтоосон;
 - 7.2. Тээврийн хэрэгслийн жолооны механизмын эд ангиудын хийцийг өөрчилсөн, жолооны механизмын бэхэлгээ эвдэрсэн, жолооны механизмын үйлдвэрээс хийгдсэн хүчлүүр ажиллахгүй буюу байхгүй болсон бол;
 - 7.3. Хөдөлгүүрийн тэжээлийн системийн битүүмж алдагдсан, шатах тослох материал гоожсон, хурдны хайрцгийн араа өөрөө салдаг эсвэл хүндрэлтэй залгагддаг;
 - 7.4. Гэрлийн тоо, хэлбэр, өнгө байрлал, ажиллах горим нь тухай тээврийн хэрэгсэлд тохироогүй, гэрэлтүүлэг, дохиоллын системийн унтраалга, шилжүүлгүүд гэмтсэн;
8. Тээврийн хэрэгслийн дор дурдсан эд ангиудад учирсан аливаа хохирол. Үүнд:
 - 8.1. Үйлдвэрийн бус нэмэлт тоноглол, хэрэгсэлд учирсан хохирол;
 - 8.2. Дугуйнд учирсан хохирол болон дугуйны хулгай;
9. Үйлдвэрийн гажиг түүнээс үүдэн гарсан хохирол
10. Тээврийн хэрэгслийг дор дурдсан зориулалтаар ашигласны улмаас учирсан аливаа хохирол. Үүнд:
 - 10.1. Тээврийн хэрэгслийг уралдаан тэмцээнд ашигласан, уул усанд найдвартай эсэхийг нь эсвэл туулах чадварыг нь туршсанаас үүссэн хохирол;
 - 10.2. Тээврийн хэрэгслийн сургалтад болон туршилтад ашиглах;
 - 10.3. Тээврийн хэрэгслээр хориотой ачаа болон тэсрэх дэлбэрэх, цацраг идэвхт бодис тээвэрлэсэн;
11. Улсын авто замын сүлжээнд ороогүй замаар зорчих (зорчих хэсгийн хашлага давах, явган хүний зам буюу хөвөөгөөр явах, батлагдсан замаас гарч шинэ зам гаргах) газраар явснаас үүдэн гарсан хохирол;
12. Гол мөрөн гатлах мөсөн дээгүүр явах үед гарсан хохирол;

13. Тээврийн хэрэгсэлд засвар, үйлчилгээ хийх, зориулалтын бус эд анги тавих дор дурдсан аливаа шалтгаануудын улмаас учирсан хохирол. Үүнд:
 - 13.1. Засвар, үйлчилгээ, цэвэрлэгээ, будалт, нөхөн сэргээх зэрэг үйлчилгээний улмаас үүссэн эвдрэл, гэмтэл өөрчлөлтүүд;
 - 13.2. Техникийн шаардлага зөрчсөн засвар хийсэн, тухайн тээврийн хэрэгсэл дээр зориулалтын бус эд анги тавих тэдгээрийн үр дагавар;
14. Тээврийн хэрэгслийн даац болон зорчигчдын тоог хэтрүүлсэн;
15. Тээврийн хэрэгсэлд зохисгүй түлш, шатахуун хэрэглэсний улмаас үүдсэн хохирол;
16. Өвлийн цагт хөдөлгүүр халаах болон бусад зориулалтаар ил гал гаргаснаас үүдсэн хохирол;
17. Гуравдагч этгээдэд учруулсан хохирол;
18. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна учирсан хохирол;
19. Дайн байлдаан, үймээн, самуун, бослого, хөдөлгөөн, нийгмийн эмх замбараагүй байдал, төрийн эргэлт, террорист үйл ажиллагааны үр дагавар; (Мин, тропед, бөмбөг эсвэл бусад тэсрэх бодис, байлдааны зэвсгийн үйлчилгээнээс үүдэлтэй хохирол; Цацраг идэвхт, хими, химийн хорт, биологи, био-химийн бодис, түүний бохирдолт болон үүдсэн үр дагавар, түлш болон түүний шаталтаас ялгарсан хог хаягдлын шууд болон шууд бус, үр дагаврын чанартай үйлчлэл)
20. Дугуйнаас үүдэн гарсан аливаа хохирол;